



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2022 /33/ НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Орхон аймаг 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70358033 Цахим хаяг: Narmandakh.ts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас:70355805 Цахим хаяг: Erdene.b@audit.gov.mn</p> <p>Аудитор: О.Хэрлэнзаяа Утас: 70357955 Цахим хаяг: Kherlenzayao@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа .....	14
4.2 Төлбөрийн акт .....	14
4.3 Албан шаардлага .....	15
4.4 Зөвлөмж.....	15

## **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.03.25 № 45  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.ЖИГДЭНГОМБО ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>60,975,626.45</b>	<b>67,600,181.18</b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>60,975,626.45</b>	<b>67,600,181.18</b>
354	<b>Хангамжийн материал</b>	<b>60,975,626.45</b>	<b>67,600,181.18</b>
35410	Бичиг хэргийн материал	5,894,736.16	6,443,198.16
35420	Аж ахуйн материал	26,064,680.00	23,935,389.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,276,700.00	975,200.00
35470	Эм боох материал	25,739,510.29	36,246,394.02
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>178,808,331.45</b>	<b>118,546,358.40</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>178,808,331.45</b>	<b>118,546,358.40</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>176,543,810.31</b>	<b>116,567,829.36</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,879,924.00	4,879,924.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-334,863.69	-492,167.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	205,158,464.40	178,021,464.40
39204	Хуримтлагдсан элэгдэл	-146,517,401.73	-138,105,868.34
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	325,701,073.00	330,085,773.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-240,288,165.66	-280,763,939.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,661,372.00	52,061,672.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40,443,871.27	-45,490,971.31
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,790,500.00	20,321,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-63,220.74	-3,949,257.30
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>2,264,521.14</b>	<b>1,978,529.04</b>
39301	Програм хангамж	2,861,500.00	2,861,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,476,978.86	-1,762,970.96
39303	Бусад биет бус хөрөнгө	880,000.00	880,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>239,783,957.90</b>	<b>186,146,539.58</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>239,783,957.90</b>	<b>186,146,539.58</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>239,783,957.90</b>	<b>186,146,539.58</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	168,305,301.79	168,305,301.79
51101	Өмч: - төрийн	168,305,301.79	168,305,301.79
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>61,270,273.29</b>	<b>7,632,854.97</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-82,277,650.80	61,270,273.29
51220	Тайлант үеийн үр дүн	143,547,924.09	-53,637,418.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,208,382.82	10,208,382.82
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>239,783,957.90</b>	<b>186,146,539.58</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,110,894,223.40</b>	<b>947,159,987.30</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>175,633,923.40</b>	<b>39,574,223.30</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>175,633,923.40</b>	<b>39,574,223.30</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	175,633,923.40	39,574,223.30
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,500,750.00	31,322,550.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	143,133,173.40	8,251,673.30

13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>935,260,300.00</b>	<b>907,585,764.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>935,260,300.00</b>	<b>901,397,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	914,960,300.00	900,519,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>20,300,000.00</b>	<b>7,066,764.00</b>
131101	Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө	20,300,000.00	878,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	6,188,764.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>967,346,299.31</b>	<b>1,000,797,405.62</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>967,346,299.31</b>	<b>1,000,797,405.62</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>858,645,391.48</b>	<b>882,827,755.51</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>581,365,663.97</b>	<b>557,490,208.65</b>
210101	Үндсэн цалин	407,067,644.42	405,350,245.73
210102	Нэмэгдэл	147,806,730.26	135,473,882.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,093,242.52	13,647,258.72
210104	Урамшуулал	8,398,046.77	3,018,821.23
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,093,066.54</b>	<b>73,218,946.59</b>
210201	Тэтгэврийн даатгал	49,209,873.78	51,587,535.89
210202	Тэтгэмжийн даатгал	5,789,396.89	5,756,949.16
210203	ҮОМШ өвчний даатгал	4,624,797.53	4,484,347.11
210204	Ажилгүйдлын даатгал	1,133,545.29	1,035,465.43
210205	Эрүүл мэндийн даатгал	11,335,453.05	10,354,649.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>71,823,067.04</b>	<b>69,211,533.13</b>
210301	Гэрэл цахилгаан	5,823,500.00	4,882,618.14
210302	Түлш, халаалт	7,644,875.88	7,026,726.66
210303	Цэвэр, бохир ус	6,562,563.16	5,910,060.33
210304	Байрны түрээс	51,792,128.00	51,392,128.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>42,017,165.45</b>	<b>40,333,053.02</b>
210401	Бичиг хэрэг	9,249,226.78	9,514,816.00
210402	Тээвэр, шатахуун	18,031,100.00	18,616,800.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	8,215,947.56	8,059,867.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	246,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,369,950.00	4,141,570.00
210408	Бараа материал акталсны зардал	3,904,941.11	0.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>10,386,122.26</b>	<b>11,892,439.57</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,604,260.26	9,642,439.57
210502	Хоол, Хүнс	3,781,862.00	2,250,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>30,881,325.00</b>	<b>39,602,265.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	23,919,925.00	20,046,201.00
210604	Урсгал засвар	6,961,400.00	19,556,064.00
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>8,092,400.00</b>	<b>3,391,497.00</b>
210702	Дотоод албан томиллолт	8,092,400.00	3,391,497.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,630,513.20</b>	<b>18,002,039.50</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,964,800.00	11,930,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,172,600.00	745,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,560,000.00	1,560,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,525.00	264,447.50
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,025,500.00	2,025,500.00
210807	Газрын төлбөр	415,600.00	210,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,102,488.20	1,167,592.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>32,356,068.02</b>	<b>69,685,773.05</b>
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	889,750.00	1,108,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	31,466,318.02	68,577,673.05
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>108,700,907.83</b>	<b>117,969,650.11</b>

2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>81,252,790.83</b>	<b>95,198,758.11</b>
213101	Орлого төвлөрүүлэлт	32,500,750.00	31,322,550.00
213102	Татан төвлөрүүлэлт	48,752,040.83	63,876,208.11
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>27,448,117.00</b>	<b>22,770,892.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,403,117.00	19,520,892.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,045,000.00	3,250,000.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>143,547,924.09</b>	<b>-53,637,418.32</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>143,547,924.09</b>	<b>-53,637,418.32</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
4-01	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	168,305,301.79	10,208,382.82	-82,277,650.80	0.00	96,236,033.81
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	168,305,301.79	10,208,382.82	-82,277,650.80	0.00	96,236,033.81
4-04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	143,547,924.09	0.00	143,547,924.09
4-01	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	168,305,301.79	10,208,382.82	61,270,273.29	0.00	239,783,957.90
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	168,305,301.79	10,208,382.82	61,270,273.29	0.00	239,783,957.90
4-04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
4-08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-53,637,418.32	0.00	-53,637,418.32
4-01	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	168,305,301.79	10,208,382.82	7,632,854.97	0.00	186,146,539.58

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	967,761,050.00	938,908,314.00
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	32,500,750.00	31,322,550.00
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	32,500,750.00	31,322,550.00
120003	Төсөвт байгууллагын өөрийн орлого	32,500,750.00	31,322,550.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	935,260,300.00	907,585,764.00
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	914,960,300.00	900,519,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	914,960,300.00	900,519,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20,300,000.00	7,066,764.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	6,188,764.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,300,000.00	878,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	946,025,750.00	930,592,614.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	946,025,750.00	930,592,614.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	837,324,842.17	812,622,963.89
2101	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	581,365,663.97	557,490,208.65
210101	Үндсэн цалин	407,067,644.42	405,350,245.73
210102	Нэмэгдэл	147,806,730.26	135,473,882.97
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	18,093,242.52	13,647,258.72
210104	Урамшуулал	8,398,046.77	3,018,821.23
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	72,093,066.54	73,218,946.59
210201	Тэтгэврийн даатгал	49,209,873.78	51,587,535.89
210202	Тэтгэмжийн даатгал	5,789,396.89	5,756,949.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,624,797.53	4,484,347.11
210204	Ажилгүйдлийн даатгал	1,133,545.29	1,035,465.43
210205	Эрүүл мэндийн даатгал	11,335,453.05	10,354,649.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	71,823,067.04	69,211,533.13
210301	Гэрэл, цахилгаан	5,823,500.00	4,882,618.14
210302	Түлш, халаалт	7,644,875.88	7,225,408.26
210303	Цэвэр, бохир ус	6,562,563.16	5,711,378.73
210304	Байрны түрээс	51,792,128.00	51,392,128.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	38,761,097.56	39,882,567.02
210401	Бичиг хэрэг	9,810,600.00	9,811,500.00
210402	Тээвэр, шатахуун	17,574,500.00	18,076,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,215,947.56	8,059,867.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	246,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,914,050.00	3,934,400.00
2105	<b>Нормативт зардал</b>	20,035,392.06	17,757,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,253,530.06	15,507,300.00
210502	Хоол, хүнс	3,781,862.00	2,250,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	33,217,650.00	32,488,564.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	21,789,550.00	15,750,000.00

210604	Урсгал засвар	11,428,100.00	16,738,564.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	8,092,400.00	3,391,497.00
210702	Дотоод албан томилолт	8,092,400.00	3,391,497.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,046,755.00	18,074,247.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,878,730.00	11,970,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,172,600.00	745,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,560,000.00	1,560,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,525.00	264,447.50
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,025,500.00	2,025,500.00
210807	Газрын төлбөр	415,600.00	210,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,604,800.00	1,199,800.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	889,750.00	1,108,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	889,750.00	1,108,100.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	108,700,907.83	117,969,650.11
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	48,752,040.83	63,876,208.11
213102	Татан төвлөрүүлэлт	48,752,040.83	63,876,208.11
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	27,448,117.00	22,770,892.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,403,117.00	19,520,892.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,045,000.00	3,250,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	32,500,750.00	31,322,550.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,500,750.00	31,322,550.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	21,735,300.00	8,315,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	21,735,300.00	8,315,700.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	21,735,300.00	8,315,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,735,300.00	8,315,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,735,300.00	8,315,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-21,735,300.00	-8,315,700.00
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	0.00	0.00
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	21,735,300.00	8,315,700.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0.00	0.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0.00	0.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>900,519,000.00</b>	<b>836,642,791.89</b>	<b>63,876,208.11</b>	<b>92.91</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>900,519,000.00</b>	<b>836,642,791.89</b>	<b>63,876,208.11</b>	<b>92.91</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>877,748,100.00</b>	<b>813,871,899.89</b>	<b>63,876,200.11</b>	<b>92.72</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>601,926,900.00</b>	<b>557,112,208.65</b>	<b>44,814,691.35</b>	<b>92.55</b>
Үндсэн цалин	434,033,700.00	405,350,245.73	28,683,454.27	93.39
Нэмэгдэл	146,361,300.00	135,473,882.97	10,887,417.03	92.56
Унаа хоолны Хөнгөлөлт	18,513,000.00	13,269,258.72	5,243,741.28	71.68
Урамшуулал	3,018,900.00	3,018,821.23	78.77	100.00

<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>81,260,200.00</b>	<b>73,218,946.59</b>	<b>8,041,253.41</b>	<b>90.10</b>
Тэтгэврийн даатгал	57,183,100.00	51,587,535.89	5,595,564.11	90.21
Тэтгэмжийн даатгал	6,019,300.00	5,756,949.16	262,350.84	95.64
ҮОМШӨ-ний даатгал	4,815,400.00	4,484,347.11	331,052.89	93.13
Ажилгүйдлийн даатгал	1,203,900.00	1,035,465.43	168,434.57	86.01
Эрүүл мэндийн даатгал	12,038,500.00	10,354,649.00	1,683,851.00	86.01
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>74,222,700.00</b>	<b>69,211,533.13</b>	<b>5,011,166.87</b>	<b>93.25</b>
Гэрэл, цахилгаан	5,823,500.00	4,882,618.14	940,881.86	83.84
Түлш, халаалт	7,824,900.00	7,225,408.26	599,491.74	92.34
Цэвэр, бохир ус	8,781,500.00	5,711,378.73	3,070,121.27	65.04
Байрны түрээс	51,792,800.00	51,392,128.00	400,672.00	99.23
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>40,017,300.00</b>	<b>39,382,567.02</b>	<b>634,732.98</b>	<b>98.41</b>
Бичиг хэрэг	9,811,500.00	9,811,500.00	0.00	100.00
Тээвэр, шатахуун	17,576,800.00	17,576,800.00	0.00	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,448,600.00	8,059,867.02	388,732.98	95.40
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	246,000.00	0.00	246,000.00	0.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,934,400.00	3,934,400.00	0.00	100.00
<b>Нормативт зардал</b>	<b>21,073,000.00</b>	<b>21,073,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,823,000.00	18,823,000.00	0.00	100.00
Хоол, хүнс	2,250,000.00	2,250,000.00	0.00	100.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>31,299,800.00</b>	<b>31,299,800.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,750,000.00	15,750,000.00	0.00	100.00
Урсгал засвар	10,549,800.00	10,549,800.00	0.00	100.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,316,800.00</b>	<b>3,391,497.00</b>	<b>2,925,303.00</b>	<b>53.69</b>
Дотоод албан томилолт	6,316,800.00	3,391,497.00	2,925,303.00	53.69
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>20,523,300.00</b>	<b>18,074,247.50</b>	<b>2,449,052.50</b>	<b>88.07</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,970,300.00	11,970,300.00	0.00	100.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,910,400.00	745,200.00	2,165,200.00	25.60
Даатгалын үйлчилгээ	1,560,000.00	1,560,000.00	0.00	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	298,500.00	264,447.50	34,052.50	88.59
Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000.00	99,000.00	44,000.00	69.23
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,025,500.00	2,025,500.00	0.00	100.00
Газрын төлбөр	415,600.00	210,000.00	205,600.00	50.53
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,200,000.00	1,199,800.00	200.00	99.98
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,108,100.00</b>	<b>1,108,100.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	1,108,100.00	1,108,100.00	0.00	100.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,770,900.00</b>	<b>22,770,892.00</b>	<b>8.00</b>	<b>100.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>22,770,900.00</b>	<b>22,770,892.00</b>	<b>8.00</b>	<b>100.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,520,900.00	19,520,892.00	8.00	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,250,000.00	3,250,000.00	0.00	100.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Хэрлэнзаяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Мэргэжлийн хяналтын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02/31 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Зорилго: Орхон аймгийн нутаг дэвсгэрт хуулийг сахиулан, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх, хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Зорилт: Эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлж, иргэн аж ахуйн нэгж, байгууллагын бизнес эрхлэх таатай орчинг дэмжиж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж зорилт дэвшүүлсэн байна.

Чиг үүрэг: Хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх замаар болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТ хууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын дотоод хяналтын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар:

2020 онд газрын даргын А/02 дугаар тушаалаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ёс зүйн зөвлөл нь 2021 оны үйл ажиллагааг 6 ажил гүйцэтгэхээр төлөвлөж, хэрэгжилт 90% байна. Ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчилэн Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Улсын ерөнхий байцаагчийн 2021 оны 01/02 дугаартай албан даалгаврыг хэрэгжүүлэх 11 арга хэмжээг төлөвлөн, биелэлтийг 85% хангасан байна. Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийг ашиг сонирхлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тус тус мөрдөн ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэд баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 900,519.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 13,507.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 9,455.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,637.4 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	60,975.6	67,600.1	6,624.5
Үндсэн хөрөнгө	178,808.3	118,546.3	-60,262.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>239,783.9</b>	<b>186,146.5</b>	<b>-53,637.4</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо/Эздийн өмч/	239,783.9	186,146.5	-53,637.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>239,783.9</b>	<b>186,146.5</b>	<b>-53,637.4</b>

2021 онд төсвийн урсгал санхүүжилтээр нийт 900,519.0 мянган төгрөгийн санхүүжилт авч төсвийн хуваарийн дагуу зардлыг зориулалт тус бүрээр зарцуулан сар бүр гүйцэтгэлийн мэдээ, улирал бүр санхүүгийн тайлан гарган цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллажээ.

Үндсэн үйл ажиллагааны орлого

2021 онд лабораторийн шинжилгээний орлогоор 25,000.0 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласан ба тайлант хугацаанд 31,322.5 мянган төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлт 125 хувьтай байна.

❖ Бараа материал

МХЕГ-аас 7,628.2 мянган төгрөгийн хөдөлмөр хамгаалын хэрэгсэл, үнэт цаас, гэрчилгээ, мэдэгдэл, 3.4 мянган төгрөгийн байцаагчийн буцаасан үнэт цаас, шатахууны урамшуулалд 546.8 мянган төгрөгийн талон үнэ төлбөргүй хүлээн авч, 86,043.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 79,142.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 67,600.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материал өмнөх оноос 6,624.6 мянгаар төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

❖ Үндсэн хөрөнгө

Багаж хэрэгслийн зардлаас 5,000.0 мянган төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж болон 3-н үйлдэлт хэвлэгч, вэб камер, тоос сорогч, ус шүүгч авсан. Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгслийн зардлаас 3,315.7 мянган төгрөгийн лабораторийн усан ванн, сэгсрэгч, пеститидын үлдэгдэл хэмжигч зөөврийн багаж зэрэг тоног төхөөрөмж худалдан авч орлогод бүртгэсэн.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөгөө**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 890,819.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 890,819.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төлөвлөгөөг 890,819.0 мянган төгрөгөөр анх баталж, 12-р сард дахин тодотгож 9,700.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 900,519.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 900,519.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 900,519.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 890,819.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 836,642.7 мянган төгрөгийг зарцуулж 63,876.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 836,642.7 мянган төгрөг буюу 92.9 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,449.0 мянган төгрөгөөр, цалин хөлс, болон нэмэгдэл урамшилын зардлыг 44,184.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 8,041.2 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5,011.1 мянган төгрөгөөр, томилолт зочны зардлыг 2,925.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Нэмэлт төсвийн дансанд 7,066.7 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэн. Түүний 6,188.7 мянган төгрөгийг Мэргэжлийн хяналтын газрын лаборторын өрөөний агааржуулах хоолойг засварлахад, 878,0 мянган төгрөгийг ковидын үед ажилласан 3 албан хаагчын унаа, хоолны зардалд тус тус зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгаан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 талбарын мэдээллээс хугацаандаа оруулсан 147 талбарын мэдээлэл, хугацаа хоцроосон 2 талбарын мэдээлэл байна.

Төсвийн гүйцэтгэлийн 1,2,3,4 -р улирлын тайлан, санхүүгийн тайлан хагас жилээр, Тендер шалгаруулсан худалдан авах ажиллагааны тоо-1, тендерт шалгарсан оролцогчийн

талаарх товч мэдээллийг оруулсан, тендерт шалгараагүй оролцогчийн хуулийн үндэслэл, шалтгааны талаарх мэдээллийг оруулаагүй байна.

Таван сая төгрөгөөс дээш нийт 2 худалдан авалт хийгдсэн. Хуулийн хугацаанд мэдээллэсэн. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгийн 17,300.0 мянган үнийн дүн бүхий 2 зарлагын гүйлгээг хугацаа хоцроож мэдээллэсэн байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар бараа материалыг нэг хүн дээр олноор зарлагдахгүй байх гэсэн зөвлөмж өгсөн. Бараа материалыг хүн тус бүрээр зарлагдсан байна. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг 100% гүйцэтгэсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн дансыг авч үзэж болох юм.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 18,386.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 36.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 196.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 845.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 5 сая төгрөгөөс дээш 2 зарлагын гүйлгээг хугацаа хоцроож мэдээллэсэн 17,300.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансны хуулийн хугацаанд мэдээллээгүй, шатахууны талон зарцуулалтын анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн бүрдүүлээгүй алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Байцаагчийн хүчингүй болсон шийтгэвэрийн хуудас болох 32.0 мянган төгрөгийн шийтгэвэрийн хуудсыг Мэргэжлийн хяналтын Ерөнхий газарт шилжүүлсэн боловч хасалт хийгээгүй алдааг санхүүгийн тайланд залруулсан.

### **4.2 Төлбөрийн акт**

1. Байгууллагын удирдлага өөрөө өөртөө томилолт өгч, эрх бүхий этгээдээр баталгаажуулаагүй 138.0 мянган төгрөгийн томилолтын зардал зарцуулсан байна.

Энэ нь ЗГ-ын 2019 оны 6 дугаар тогтоолын 2.1. “Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2. Жаргалант суманд ажилласан 2 ажилтанд томилолтын зардал олгохдоо зочид буудлын зардалд 58.0 мянган төгрөг олгосон хэдий ч анхан шатны баримтанд зочид буудлын төлбөр төлсөн баримт байхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх 2 зөрчилд төлбөрийн акт тогтоов.

#### **4.3 Албан шаардлага**

Орхон аймгийн Засаг даргын А/692 дугаар захирамжаар Мэргэжлийн хяналтын газрын даргыг 1 сарын үндсэн цалингаар байгууллагын өөрийн төсөвтөө багтаан шагнаж урамшуулах шийдвэр гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.6.2-д "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх," 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," 40.3-д "Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ.", ЗГ-ын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-д "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараахь эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", 1.2.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээллэлд 5 сая төгрөгөөс дээш 17,300.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 2 зарлагын гүйлгээг хугацаа хоцроож мэдээллэсэн.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 14.3.1 дэх заалтын дагуу мэдээллийг хуулийн хугацаанд мэдээллэж байх.

##### **2. Хангамж, бараа материалын зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: .

Шатахууны талоныг олгохдоо явсан км бүрээр тооцож олгоогүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 14.3.1 дэх заалтын дагуу анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Мэргэжлийн хяналтын газар	6	18,382.5	1	32.0	2	196.0	1	854.5	2	17,300.0



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 04/Н.ОМ-2022/33 /НА-СТА-ТШЗ Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын удирдлага өөрөө өөртөө томилолт өгч, эрх бүхий этгээдээр баталгаажуулаагүй 138,000 мянган төгрөгийн томилолтын зардал зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2.5-д "албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, хоол, унааны зардлын төсвийг байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Томилолтын зардалд олгосон 138,000 төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Жигдэнгомбо, нягтлан бодогч Л.Ундраа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР: ..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР: ..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: ..... О.ХЭРЛЭНЗАЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 15/15 ОАА-2022/25/НА-СТА-ТШЗ Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жаргалант суманд ажилласан 2 ажилтанд томилолтын зардал олгоходоо зочид буудлын зардалд 58,000 төгрөг олгосон хэдий ч анхан шатны баримтад зочид буудлын төлбөр төлсөн баримт байхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Томилолтын зардалд олгосон 58,000 төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Жигдэнгомбо, нягтлан бодогч Л.Ундраа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР: ..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР: ..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: ..... О.ХЭРЛЭНЗАЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 25/05 ОРА-2022/33/НА-СТА-ТШЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орхон аймгийн Засаг даргын А/692 тоот захирамжаар Мэргэжлийн хяналтын газрын даргыг 1 сарын үндсэн цалингаар байгууллагын өөрийн төсөвтөө багтаан шагнаж урамшуулах шийдвэр гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.6.2-д "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх," 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 40.3-д Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ.

ЗГ-ын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-д "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно," 1.2.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.",

4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Холбогдох хууль, тогтоол, журамд үл нийцсэн тушаал гаргаж төсвийг зориулалт бусаар зарцуулж буй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Жигдэнгомбо, нягтлан бодогч Л.Ундраа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..... О.ХЭРЛЭНЗАЯА